

# **МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ САНХҮҮЖИЛТ (ТoС)-ИЙН ЗАРЧИМ**

## **БАРИЛГА, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН УДИРДАМЖ**

2015 оны 2–р сар

## АГУУЛГА

Нэр томъёоны тайлбар	3
1. Танилцуулга	5
2. Зорилго	5
3. Хэрэгжүүлэлт болон хамрах хүрээ	5
4. Барилгын салбарын байгаль орчин, нийгмийн асуудлууд	6
5. Монгол Улсын барилгын салбарын зээлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн шаардлага	7
6. Хяналт Шинжилгээ	10
7. Тайлагнал	10
Хавсралт 1: Монгол Улсын барилгын үйл ажиллагаа, холбогдох байгаль орчин, нийгмийн асуудал.....	11
Хавсралт 2: Барилгын салбарын холбогдолтой Монгол Улсын хууль тогтоомж.....	18
Хавсралт 3: Барилгын салбарын холбогдолтой үндэсний болон олон улсын байгаль орчин, нийгмийн стандарт, зарчим болон бусад баримт бичиг	19
Хавсралт 4: Барилгын салбарын холбогдолтой оролцогч талууд .....	21

## Нэр томьёоны тайлбар

Нэр томьёо	Тайлбар
Банк	Банк гэдэгт Байгаль орчин, нийгэмд ээлтэй Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмын хамтарсан тунхаг бичигт гарын үсэг зурсан Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй банкиг ойлгоно
Барилга барих	Барилга (орон сууц болон арилжааны зориулалтын) барих үйл ажиллагаа нь тодорхой үл хөдлөх хөрөнгө дээр нэмж байгууламж барих эсхүл шинээр барилга барих үйл ажиллагааг хэлнэ
Үндсэн үйл ажиллагаа	Банкнаас харилцагчдад үзүүлж буй санхүүгийн бүтээгдээхүүн, үйлчилгээний хүртээмж, тухайлбал, компанийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын банк (нөхцөл өөрчлөгдсөн зээл, хөрөнгө, худалдаа), өмчийн хөрөнгө оруулалт, төслийн санхүүжилт, бүтцийн худалдааны санхүүжилт, ЖДБ-ийн зээл, иргэдийн банк, худалдаа, лизинг, зээлийн бусад төрөл гэх мэт багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй юм
Дотоод үйл ажиллагаа	Банкнаас өөрийн үндсэн үйл ажиллагааг явуулахад шаардлагатай боловсон хүчин, өмч хөрөнгө болон дэд бүтэц (оффис, банкны салбар, тоног төхөөрөмж гэх мэт) багтана. Үүнд мөн банкнаас өөрийн үндсэн үйл ажиллагааг эрхлэх болон дотоод үйл ажиллагааг явуулахад хамтран ажиллаж буй ханган нийлүүлэгч, гэрээт байгууллага, гуравдагч үйлчилгээ үзүүлэгч талууд багтана
Монгол банк	Монгол Улсын Төв банк (Монгол банк)
БОНБНУ	Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ нь төслийн тусгай зөвшөөрөл авахад шаардлагатай Байгаль орчинд нөлөөлөх байдлын илүү нарийвчилсан үнэлгээ (Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн шаардлага)
БОХТ	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө нь хэрэгжүүлж буй төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй тодорхойлогдсон сөрөг нөлөөллүүдийн хяналт шинжилгээ болон бууруулах бүх арга хэмжээнүүдийг тусгасан төлөвлөгөө юм
БОНХ	Байгаль орчин, нийгмийн хариуцлага
БОНХ-ийн эрсдэл	Бизнес болон эрсдэлийн удирдлагын шийдвэр гаргах явцад анхаарах шаардлагатай харилцагчийн эрсдэл үүсгэж болзошгүй байгаль орчин, нийгмийн асуудал
БОНХ-ийн нөлөөлөл	Банкнаас санхүүжүүлж буй бизнесийн үйл ажиллагаанаас материаллаг, байгалийн болон соёлын орчин, түүнчлэн олон нийт, ажилчдад үүсэх бодит эсвэл болзошгүй өөрчлөлтүүдийг ойлгоно. Байгаль орчин, нийгмийн нөлөөллүүд нь байгаль орчин, хүн/олон нийтэд түр зуурын эсвэл байнгын шинжтэй, нөхөн сэргээгдэх эсхүл нөхөн сэргээгдэхгүй шинжтэй байж болно. Байгаль орчны нөлөөлөлд хүний үйл ажиллагаа (хүлэмжийн хий, бохирдол, амьдрах орчны өөрчлөлт гэх мэт)-наас үүдэлтэй уур амьсгалын, усны, газар нутгийн өөрчлөлтүүд багтана. Нийгмийн нөлөөлөлд тухайн харилцагчийн ажиллах хүч болон ойр орчмын олон нийт (эрүүл мэнд, аюулгүй байдал, хүний эрх болон хөдөлмөрийн нөхцөл, газрын маргаан/нүүлгэн шилжүүлэлт, авилга гэх мэт)-д нөлөөлөх нөлөөллүүд багтана
БОНХ-ийн , шинэ боломж	Байгаль орчин, нийгмийн асуудлуудыг шийдвэрлэхтэй холбоотойгоор үүсэх шинэ бизнесийн боломж (цэвэр/сэргээгдэх техник технологийг нутагшуулах, шинэ ажлын байр бий болгох, орон нутгийг хөгжүүлэх гэх мэт)-ийг ойлгоно. Бизнесийн шийдвэр гаргах явцад байгаль орчин, нийгмийн асуудлуудыг харгалзан авч үзэх нь харилцагч болон тухайн харилцагчид санхүүгийн үйлчилгээ үзүүлж буй банкинд шинэ боломж нээж өгөх давуу талтай
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
ОУСК	Олон улсын санхүүгийн корпораци
БХБЯ	Барилга, хот байгуулалтын яам
ЭХЯ	Эрчим хүчний яам
БОНХЯ	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам

Нэр томьёо	Тайлбар
ТЗГ	Төмөр замын газар
ЗТЯ	Зам тээврийн яам
ХАБЭМ	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Үүнд: ажил, хөдөлмөр эрхэлж буй хүмүүсийн аюулгүй байдал, эрүүл мэнд, сайн сайхан байдлыг хамгаалах
Зарчмууд	МУ-ын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмууд
Тогтвортой санхүүжилт	МУ-ын эдийн засгийн урт хугацааны хөгжилд, банкууд гагцхүү санхүүгийн ашиг сонирхлоор бус байгаль орчин, нийгэмд хариуцлагатай байдлаар оролцох үүрэг хариуцлагыг тодорхойлно
Ажлын даалгавар	Ажлын даалгаварт барилгын зураг төслийг хэрхэн хийх, боловсруулах болон баталгаажуулахыг нарийн тусгана. Түүнчлэн, ажлын даалгавар нь ирээдүйн шийдвэр гаргах үйл ажиллагаа эсхүл оролцогч талуудын дунд нэгдсэн ойлголт бий болгох зэрэгт шаардлагатай үндэслэлийг баримтжуулна

## 1. Танилцуулга

Энэхүү удирдамжийг Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмууд (Зарчим)-ын дагалдах баримт бичиг болгон барилга, дэд бүтцийн салбар, салбарын үйл ажиллагаанд зээл эсвэл хувьцааны санхүүжилт олгодог банкуудад зориулж боловсруулсан байна. Үүнд:

Зарчим 1 | Байгаль орчныг хамгаалах

Зарчим 2 | Ажилчид болон нутгийн иргэдийг хамгаалах

Зарчим 3 | Түүх, соёлын өвийг хамгаалах

Зарчим 4 | Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих

Зарчим 5 | Санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох

Зарчим 6 | Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих

Зарчим 7 | Хариуцлагатай, ил тод байдлыг дэмжих

Зарчим 8 | Манлайлан үлгэрлэх

Барилгын салбарын төслийг санхүүжүүлж, харилцагчдад зээл олгож буй банкууд шинэ харилцагч, төсөл, зээлийг үнэлэхдээ Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмууд болон энэхүү салбарын удирдамжийг мөрдөх шаардлагатай. Салбарын удирдамжийг Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудад нийцэж, эдгээрийн хэрэгжүүлэлтийг дэмжсэн байхаар загварчилсан юм. Энэхүү Салбарын удирдамж нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийн удирдлагад гол төлөв анхаарлаа хандуулсан боловч банкууд эрсдэлийн удирдлагаас гадна байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг сайжруулах боломжийг хайх шаардлагатай.

## 2. Зорилго

Барилгын салбарын энэхүү удирдамж нь барилгын салбарын харилцагчдад зээл олгохтой холбоотойгоор үүсэж болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдэл, боломжийг үнэлэхэд нь банкуудад дэмжлэг үзүүлэх зорилготой. Удирдамжийг дараах үйл ажиллагааг дэмжих зорилгоор боловсруулсан. Үүнд:

- Барилгын салбарын харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэл, боломжийг тодорхойлохийг зэрэгцээ харилцагчийн байгаль орчин, нийгмийн асуудлуудыг (**Хавсралт 1, Хүснэгт 1**-ийг харна уу) удирдах чадварыг тодорхойлох;
- Барилгын салбарын үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгмийн эрсдэлийг зээл болон харилцагчийн түвшинд үнэлж, ангилах боломжтой байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний шалгуурыг бий болгох;
- Барилгын салбарын харилцагчдад зээл болон санхүүжилт олгохтой холбоотой үүсэх байгаль орчин, нийгмийн эрсдэлийг зохицуулах салбарын холбогдолтой олон улсын стандарт, тэргүүн туршлагыг авч хэрэгжүүлэх;
- Барилгын салбарын харилцагчдад зээл болон санхүүжилт олгох явцдаа ил тод байдал, хариуцлага тооцох хандлагыг авч хэрэгжүүлэх;
- Шаардлагатай тохиолдолд, харилцагчийн байгаль орчин, нийгмийн гүйцэтгэлийг сайжруулах боломжийг тодорхойлж, эрэлхийлнэ.

## 3. Хэрэгжүүлэлт болон хамрах хүрээ

Энэхүү удирдамжийг Зарчмуудыг хэрэгжүүлж буй Монгол Улсын банкууд авч хэрэгжүүлэх бөгөөд барилгын салбарын харилцагч, хөрөнгө оруулж буй компаниудын эрхлэдэг үндсэн үйл ажиллагааг хамруулна. Удирдамжинд барилгын салбарын дараах үйл ажиллагаа багтах бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

1. Барилга байгууламж (тухайлбал, төсөл болон бизнесийн санхүүжүүлэлт, зээл, тендерийн баталгаа, зээл болон холбогдолтой үйл ажиллагаа (Засгийн газраас хэрэгжүүлж буй хөтөлбөртэй холбоотойгоор Төрийн сан ба олон улсын сангуудаас хийгдэж буй санхүүжүүлэлт)); ба
2. Дэд бүтцийн бүтээн байгуулалт.

Дээр хоёр бүлэгт багтах дэд салбарын үйл ажиллагааг доорхи хүснэгтээс харна уу.

Салбарын үйл ажиллагаа	Дэд салбарын үйл ажиллагаа
Барилга байгууламж	<ul style="list-style-type: none"> <li>• Орон сууц, худалдаа үйлчилгээний зориулалттай барилга байгууламж;</li> <li>• Аж үйлдвэрийн зориулалттай барилга байгууламж.</li> </ul>
Дэд бүтэц	<ul style="list-style-type: none"> <li>• Дэд бүтцийн бүтээн байгуулалт: <ul style="list-style-type: none"> <li>• Зам;</li> <li>• Төмөр зам;</li> <li>• Эрчим хүч үйлдвэрлэх байгууламж, жишээ нь: <ul style="list-style-type: none"> <li>• Салхин тээрэм;</li> <li>• Нарны эрчим хүч үйлдвэрлэгч;</li> <li>• Нүүрсэн галлагаат дулааны цахилгааны цахилгаан станци;</li> <li>• Усан цахилгаан станци.</li> </ul> </li> <li>• Усны байгууламж;</li> <li>• Хог хаягдлын байгууламж; ба</li> <li>• Бусад байгууламж.</li> </ul> </li> </ul>

Энэхүү удирдамж тусгасан байгаль орчин, нийгмийн эрсдэлүүд нь барилгын салбарын үйл ажиллагаатай холбоотойгоор банкны харилцагч, түүний ханган нийлүүлэгчийн үйл ажиллагаанаас байгаль орчин, нутгийн иргэдэд учирч болзошгүй нөлөөлөл, эрсдэлүүдэд хамааралтай. **Хавсралт 1: Барилгын салбарын үйл ажиллагаа, холбогдолтой байгаль орчин, нийгмийн эрсдэл**-ийг харна уу.

#### 4. Барилгын салбарын байгаль орчин, нийгмийн асуудлууд

Барилгын салбарын харилцагч, төсөлд санхүүжилт, зээл олгохдоо банк нь дараах нөхцлүүдийг харгалзан байгаль орчин, нийгмийн эрсдэлүүдийг үнэлэх шаардлагатай бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:

- Барилгын салбарын үйл ажиллагааны төрөл болон цар хүрээ (**Хүснэгт 1**-ийг харна уу);
- Байгалийн баялаг, тусгай хамгаалалтын газар нутаг, суурин газар, түүнтэй холбоотой эдийн засгийн үйл ажиллагаа зэргийг хамаарсан барилгын төслийн газарзүйн байршил; ба
- Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл (тухайлбал, бохирдол, биологийн олон янз байдлын алдагдал, байгалийн нөөцийн хомсдол, хог хаягдал, хийн хаягдлын ялгарал); нийгэмд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл (хүний эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд учирч болзошгүй аюулууд, эдийн засгийн нүүлгэн шилжүүлэлт болон бусад), болон бүс нутгийн соёлын өвд учирч болзошгүй аюул (**Хавсралт 1**-ийг харна уу).

Байгаль орчин, нийгмийн зарим асуудлууд эрсдэлийн өндөр түвшинд багтана. Доорхи хүснэгтэнд өндөр, дунд зэргийн эрсдэл бүхий зээлийн үйл ажиллагааны жишээг харуулав:

Эрсдэлийн түвшин	Нэмэлт мэдээлэл
<p><b>Өндөр эрсдэлтэй</b> зээлийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэмд их хэмжээний, олон төрлийн, үл сэргээгдэх сөрөг эрсдэл, нөлөөлөл учруулж болзошгүй дараах үйл ажиллагаа багтана</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Монгол Улсын байгалийн болон соёлын үнэт өвийн ач холбогдол бүхий газар нутагт (тусгай хамгаалалттай газар) ойр байрлах барилгын төслүүд;</li> <li>• Олон улсын зарим санхүүгийн байгууллагын санхүүжүүлэх Хориотой жагсаалтанд орсон асбестэн мяндас ашигладаг барилгын бүх төслүүд;</li> <li>• Байгалийн нөөцийн хомсдолд хүргэх зам дагуух барилгын материалын өндөр, хяналтгүй хэрэглээтэй зам, төмөр замын төслүүд;</li> <li>• Нүүлгэн суурьшуулалт болон эдийн засгийн эсхүл биет нүүлгэн шилжүүлэлтийн эрсдэлтэй зам, төмөр замын төслүүд;</li> <li>• Хүний эрүүл мэндэд аюул учруулж болзошгүй аюултай химийн бодис ашигладаг төслүүд.</li> </ul>
<p><b>Дунд зэргийн эрсдэлтэй</b> зээлийн үйл ажиллагаанд байгаль орчин, нийгэмд орон нутгийн шинж чанартай, бага хэмжээний, нөхөн сэргээгдэх боломжтой сөрөг эрсдэл / нөлөөлөл учруулах үйл ажиллагаа багтана</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Соёл амралтын газаргүй болох, газрын маргаан үүсэх зэрэг орон нутгийн иргэдийн маргааны асуудалтай барилгын төслүүд; ба</li> <li>• Барилгын техникийн шаардлагуудад нийцэхгүй орон сууцны болон арилжааны зориулалттай барилгын төслүүд</li> </ul>

## 5. Монгол Улсын барилгын салбарын зээлтэй холбоотой байгаль орчин, нийгмийн шаардлага

Монгол Улсын Тогтвортой санхүүжилт (ТоС)-ийн зарчмуудын талаар авсан үүрэг амлалтандаа хүрэх, барилгын салбарын харилцагч, зээлтэй холбоотой БОНХ-ийн асуудлыг шийдвэрлэхийн тулд банк тус бүр өөрийн БОНХ-ийн менежментийн системийг боловсруулж хэрэгжүүлнэ. Энэхүү БОНХ-ийн менежментийн систем нь барилгын салбарын БОНХ-ийн эрсдэлтэй холбоотой асуудлыг тодорхойлж, үнэлэх, шийдвэрлэх, байнгын мониторинг хийхэд банкинд туслах юм.

БОНМС-ийн нэг хэсэг болгон банк нь барилгын салбарын үйл ажиллагааг үнэлэхдээ холбогдох Зарчмыг хэрэглэх явдал юм. Ялангуяа барилгын салбарын харилцагч, төсөл, зээлтэй холбоотой асуудлаар Банкинд хамгийн их хамааралтай нь Зарчим 1: Байгаль орчныг хамгаалах, Зарчим 2: Ажилчид болон нутгийн иргэдийг хамгаалах, Зарчим 3: Түүх, соёлын өвийг хамгаалах Зарчим 4: Ногоон эдийн засгийн өсөлтийг дэмжих , Зарчим 5: Санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй болгох, Зарчим 6: Ёс зүйтэй санхүүжилт, компанийн засаглалыг дэмжих зэрэг юм.

Барилгын салбарын харилцагч, төсөл, зээлтэй холбоотой БОНХ-ын шаардлагыг банк нь өөрийн БОНМТ-доо нэгтгэх бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй:

Шаардлага	Нэмэлт мэдээлэл
<p>1. Харилцагчийн (шаардлагатай тохиолдолд, гүйцэтгэгчийн) барилгын үйл ажиллагаатай холбоотой бичиг баримт, зөвшөөрлийн анхан шатны шалгалт хийх.</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Барилгын компани: барилгын компани нь өөрийн гэрээт гүйцэтгэгчийн бичиг баримтыг шалгах бөгөөд үүнд холбогдох төрийн байгууллагын тусгай зөвшөөрөл (<b>Хавсралт 2 ба 3</b>-ыг харна уу);</li> <li>• Барилгын зураг төсөл эсхүл зам болон төмөр замын маршрут зэргийн зөвшөөрөл. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Дулааны холболтын зөвшөөрөл;</li> <li>• Усны болон бохир ус зайлуулах холболтын зөвшөөрөл;</li> <li>• Галын аюулгүй байдлын зөвшөөрөл;</li> <li>• Ариун цэврийн байгууллагаас олгох зөвшөөрөл;</li> <li>• Ерөнхий архитекторын зөвшөөрөл;</li> <li>• Улаанбаатар хотын Цахилгаан түгээх сүлжээний зөвшөөрөл; ба</li> <li>• Улсын техникийн комиссын акт..</li> </ul> </li> <li>• Кадастрын төлөвлөгөө, газар эзэмших гэрээ болон барилгын ажил эхлүүлэх зөвшөөрөл;</li> <li>• МХЕГ болон Улаанбаатар хотын захиргааны зөвшөөрөл (барилгын материал нь Монгол Улсын барилгын норм дүрмийн шаардлагад нийцсэн байх шаардлагатай);</li> <li>• Ажлын даалгавар, төслийн техникийн нөхцөл;</li> <li>• Хог хаягдал зайлуулах гэрээ: хатуу, аюултай, аюулгүй, бохир ус гэх мэт хог хаягдлын төрлүүд;</li> <li>• Байгууллагын үйл ажиллагааг Зарчим 6 дахь санхүүжүүлэхийг хориглосон нэгдсэн жагсаалтын дагуу шалгах;</li> <li>• Барилгад ашиглах материалыг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр ашиглахыг хориглосон болон хязгаарласан химийн аюултай бодисын жагсаалтын дагуу шалгах;</li> <li>• Харилцагч (барилгын компани нь өөрийн гэрээт гүйцэтгэгчийн менежментийн системг хариуцна)-ийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, байгаль орчин, нийгэм, чанарын менежментийн бодлого, журам, бүртгэлийг шалгах;</li> <li>• Барилгын төслийн Улаанбаатар хотын Байгаль орчны газрын БОНБ-ын ерөнхий үнэлгээ;</li> <li>• Техник эдийн засгийн үндэслэл, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ эсхүл БОНБНҮ (дэд бүтцийн бүтээн байгуулалт болон үйлдвэрлэлийн зориулалттай байгууламжийн том төслүүд);</li> <li>• Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөг багтаасан байгууллагын байгаль орчин хамгаалах төлөвлөгөө;</li> <li>• Байгаль орчин, нийгмийн өндөр эрсдэлтэй барилгын төсөл дээр төслийн цар хүрээ (том, дунд, жижиг), үйл ажиллагааны төрөл (химийн үйлдвэр барихад тавигдах барилгын норм дүрмийн шаардлагууд илүү нарийн), байршил (суурин газар, тусгай хамгаалалттай газарт ойр байх), компанийн чадавхи, нэр хүнд (харилцагчийн ХАБЭХ-н гүйцэтгэлийн бүртгэл тэмдэглэлийг шалгах) зэргийн талаар мэргэжлийн шинжээчийн дүгнэлт гаргуулна.</li> </ul>
<p>2. Эрсдэлийг үнэлж ангилахдаа барилгын харилцагч, зээлийн БОНХ-ийн эрсдэлийн үнэлгээний системийг боловсруулах. Үнэлгээ, ангилалын үр дүн нь харилцагчийн БОНХ-ийн эрсдэлийн түвшинг тодорхойлж, зээл олголт, багцын менежмент</p>	<ul style="list-style-type: none"> <li>• Барилгын үйл ажиллагаатай холбоотой өндөр болон дунд эрсдэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Бүлэг 4-с үзнэ үү.</li> </ul>



Шаардлага	Нэмэлт мэдээлэл
болон шийдвэр гаргахад чухал юм.	
<p>3. Барилгын салбарын зээл нь (хэмжээнээс хамааран) БОНХ-ийн холбогдох олон улсын болон үндэсний хууль тогтоомж, стандартын шалгуурыг хангаж буй эсэхийг үнэлэх <b>(Хавсралт 2 болон 3-г харна уу).</b></p>	<ul style="list-style-type: none"> <li>• Барилгын үйл ажиллагаанаас хамааран үндэсний заавал мөрдөх хууль тогтоомж, стандарт болон олон улсын сайн дурын үндсэн стандартуудыг тодорхойлох;</li> <li>• Харилцагчийн гүйцэтгэлийг эдгээр хууль тогтоомж, стандартын дагуу дараах чиглэлээр хянана. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• Байгаль орчны хамгаалал /үүгээр зөвхөн хязгаалагдахгүй/:</li> <li>• Байгаль орчны бохирдол;</li> <li>• Биологийн олон янз байдлын доройтол; ба</li> <li>• Хог хаягдлын менежмент.</li> <li>• Нийгмийн хамгаалал /үүгээр зөвхөн хязгаалагдахгүй/:</li> <li>• Орон нутгийн иргэдэд нөлөөлөх байдал</li> <li>• Ажилчдад нөлөөлөх байдал.</li> </ul> </li> <li>• Орхигдолыг тодорхойлж (БОНХ-ийн хамгийн их сөрөг эрсдэл), тэдгээрийг үйл ажиллагааны төлөвлөгөөгөөр зохицуулан шийдэх.</li> </ul>
<p>4. БОНХ-ийн их хэмжээний эрсдэлтэй барилгын салбарын харилцагчийг тодорхойлж, эрсдэлийг зохицуулж, нөлөөллийг бууруулах харилцагчийн чадварыг үнэлэх</p>	<p>Харилцагчийн зүгээс авах менежмент, нөлөөллийг бууруулах арга хэмжээ:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эрсдэлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх;</li> <li>• Талуудыг татан оролцуулах өргөн хүрээтэй, үр нөлөөтэй механизмыг бий болгох <b>(Хавсралт 4-г харна уу);</b></li> <li>• БОНХ-ийн болзошгүй эрсдэлийг 3-дагч этгээд хуваалцах зэрэг нөлөөлөл бууруулах арга хэмжээ авах.</li> </ul>

Эрсдэлийг өндөр, дунд, бага зэргээр эцсийн байдлаар ангилахдаа дээр дурдсан бүх шаардлагуудыг харгалзан үзнэ.

Өндөр болон дунд эрсдэлтэй зээлийг зөвшөөрөхөөс өмнө банк харилцагч нь байгаль орчин, нийгмийн тодорхойлогдсон сөрөг нөлөөллийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан эсэхийг шалгах хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, харилцагч (гэрээт гүйцэтгэгч) өөрийн үйл ажиллагааны байгаль орчин, нийгмийн сөрөг нөлөөлөл, байгаль орчин, нийгмийн эрсдэлийн хэмжээг бууруулах ажлуудыг багтаасан зохистой менежментийн төлөвлөгөө болон журамтай эсэхийг баталгаажуулна.

Барилгын салбарын харилцагчийн БОНХ-ийн гүйцэтгэл муу, хангалтгүй байгаа тохиолдолд банк нь үйл ажиллагааны буюу ажлын төлөвлөгөө боловсруулж өгөхийг хүсэж болно. Төлөвлөгөө нь хэрэгжихүйц, тухайн цаг хугацаатай нийцсэн мөн баримтжсан байна. Банк нь БОНХ-ийн тодорхойлогдсон эрсдлүүдийг харилцагч нь бууруулж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор уг нөхцөл, тохиролцоог зээлийн хэлцэлд оруулж өгөх бөгөөд зөрчил илэрсэн тохиолдолд харилцагч гэрээг биелүүлээгүй гэж үзнэ.

Дээрх асуудлуудыг дэмжих, нөгөө талаас банкны БОНМС-ийн нэг хэсэг болгон банк тус бүр өөрийн холбогдох бизнесийн ажил үүргийн хуваарьт БОНХ-ийн эрсдэлийн менежментийг чадавхижуулах боломжуудыг эрэлхийлэх ба үүнд БОНХ-ийн эрсдэлийн сургалт, мэргэшсэн ажилтнуудыг авч Барилгын салбарын удирдамж

ажиллуулж, сургалтанд хамруулах зэрэг асуудлууд багтана. Шаардлагатай тохиолдолд банк нь БОНХ-ийн эрсдэлийн менежмент болон сургалт явуулах зорилгоор шаардлага хангахуйц үр чадвартай хөндлөнгийн 3-дагч талыг татан оролцуулж туслалцаа авч болно. Гэхдээ энэхүү төрлийн дэмжлэг нь банкны өөрийн дотоод чадавхийг бэхжүүлэх чиглэлээр байж болохгүй.

## 6. Хяналт Шинжилгээ

Байгаль орчин, нийгмийн эрсдэлтэй барилгын салбарын зээлийг батлахаас өмнө банк нь тухайн компанийн байгаль орчин, нийгмийн эрсдэлийг үр дүнтэй бууруулах үйл ажиллагааны хүрээнд тохирсон БОНХ-ийн үйл ажиллагааны төлөвлөгөө; БОНХ-ын удирдлагын төлөвлөгөө; бусад шаардлагын хэрэгжилтэнд хяналт тавина.

## 7. Тайлагнал<sup>1</sup>

Банк нь өөрийн байгаль орчин, нийгмийн удирдлагын хэрэгжилтийн үйл явц, туршлага, барилгын салбарын харилцагч, түүний зээлийн түүхийн мэдээллийг багтаасан тайланг жилд нэг удаа Монгол банк болон Монгол Улсын банкны холбоонд ирүүлнэ (**Хавсралт 4**-г харна уу). Барилгын салбарын зээлийн үйл ажиллагааны тайланд дараах зүйлсийг тусгасан байна (үүгээр хязгаарлагдахгүй). Үүнд:

- Барилгын салбарын үнэлсэн зээлийн тоо;
- Барилгын салбарын зөвшөөрсөн зээлийн тоо;
- Барилгын салбарын үйл ажиллагааны төрөл, бүс нутгаар харуулсан байгаль орчин, нийгмийн эрсдэлийн ангилал; ба
- Тогтмол хяналт шинжилгээний шаардлага, харилцагчтай тохирсон БОНХ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөний явц.

---

<sup>1</sup> Монгол улсын банкууд тайлагналын шаардлага дээр тохирсоны дараа эргэн хянана

## **Хавсралт 1: Монгол Улсын барилгын үйл ажиллагаа, холбогдох байгаль орчин, нийгмийн асуудал**

Барилгын салбарын харилцагчийн үйл ажиллагаатай холбоотой БОНХ-ийн асуудлын мөн чанар, төрөл нь барилгын үйл ажиллагааны төрөл, цар хүрээнээс хамаарна. Барилгын компанийн БОННБҮ, БОНБНҮ-д дэлгэрэнгүй дурдсан БОНХ-ийн асуудлууд, түүнчлэн БОНХ-ийн эрсдлийн үнэлгээ, ангилалын явцад хөндөгдөөгүй асуудлыг банк нь харгалзан авч үзэх шаардлагатай. Харилцагч, түүний зээлийн БОНХ-ийн эрсдэлийн үнэлгээг хийх явцдаа дараах барилгын үйл ажиллагаа, түүнтэй холбоотой БОНХ-ийн асуудлыг харгалзан авч үзэх ёстой. Хүснэгт 1-д үзүүлсэн БОНХ-ийн асуудлууд үүгээр хязгаарлагдахгүй гэдгийг анхаарна уу.

## Хүснэгт 1: Барилгын салбарын үйл ажиллагаа болон холбогдох БОНХ-ийн асуудлууд

Салбарын үйл ажиллагаа	Дэд үйл ажиллагаа	Дэд үйл ажиллагааны задаргаа	Байгаль орчны гол асуудал	Хяналт	Нийгмийн гол асуудал	Хяналт
Орон сууц, арилжаа болон үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгуулалт	Орон сууц, худалдааны зориулалттай барилга байгууламж	<ul style="list-style-type: none"> <li>Зөвшөөрөл авах үйл явц</li> <li>Геотехникийн судалгаа</li> <li>Газар шорооны ажил</li> <li>Бетон цутгах ажил</li> <li>Төмөр/каркас угсрах ажил</li> <li>Угсралтын ажлууд: сантехник, цахилгаан, дулааны холболт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын талбайн бохирдол</li> <li>Тоосжилт, дуу чимээ, хийн хаягдлын ялгаруулалт, чичиргээний асуудлууд</li> <li>Ус, эрчим хүчний хэт хэрэглээ</li> <li>Бензин, ашигласан тос болон тосолгооны бусад материалаас үүсэх хөрсний бохирдол</li> <li>Бохир ус зэрэг хог хаягдал үүсэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хүрээлэн буй орчинд аюултай бодис, хог хаягдал, тос тосолгооны материалыг хаяхгүй байж талбайг бохирдуулахаас зайлсхийнэ<sup>2</sup></li> <li>Тоосжилт, дуу чимээ, хийн хаягдлын ялгаруулалт, чичиргээ зэргээс урьдчилан сэргийлж, хамгаалах хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх</li> <li>Эрчим хүч, усны хэт хэрэглээг багасгах; усыг эргүүлэн ашиглах зэрэг усыг үр ашигтай хэрэглэх; салхи, нар, эс зэрэг сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэр ашиглах</li> <li>Бохирдолоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө бүхий бохирдолын хяналтыг хэрэгжүүлэх (ус, хөрсний чанарын байнгын хяналт шинжилгээ)</li> <li>Аюултай, аюултай бус хог хаягдлыг бага хэмжээгээр гаргаж, хог хаягдлыг зохистой зайлуулж, байнгын хяналт шинжилгээ хийх зэргээр хог хаягдлын менементийн хяналтыг хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Гадаад ажилчдын хөдөлмөр эрхлэлттэй холбоотой нийгмийн зөрчлүүд</li> <li>Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй</li> <li>Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал</li> <li>Хүний эрх – Хөдөлмөрийн нөхцөл, ажлын цаг, хөдөлмөрийн гэрээтэй холбоотой зөрчлүүд</li> <li>Барилгын квадрат метрийн зөрүүнээс худалдан авагчид үүсэх эдийн засгийн хохирол</li> <li>Газрын маргаан – Өмчлөх эрх, нүүлгэн суурьшуулалт, хууль бусаар газар чөлөөлөх</li> <li>Амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх газруудыг алдах</li> <li>Зөвшөөрөлгүйн улмаас ус, цахилгаан, дулааны холболтууд хийгдээгүй байх</li> <li>Байгууламжтай холбоотой эрсдэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Гадаадын ажилчдад улсаас тавих хяналтыг сайжруулах; байнгын шалгалт хяналт</li> <li>Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг дагаж мөрдөх</li> <li>Нөлөөлөлд өртөх орон нутгийн иргэдэд үзүүлэх эрүүл ахуй, аюулгүй байдлын сөрөг нөлөөлөөс зайлсхийх</li> <li>Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, ОУХБ-ын Хөдөлмөрийн стандарт<sup>3</sup>, Хамтын гэрээ болон олон улсын Хүний эрхийн конвенцийн заалтуудыг дагаж мөрдөх</li> <li>Нийгмийн асуудлуудыг гаргаж ирэх боломжтой гомдол барагдуулах механизмыг хэрэгжүүлэх</li> <li>Монгол Улсан барилгын норм, дүрмийг дагаж мөрдөх</li> <li>Холбогдолтой зөвшөөрлүүдийг зохих ёсоор авах</li> <li>Байгууламжийн аюулгүй байдалтай холбоотой галын гол эрсдэл, хэрэглэгдэх норм, стандарт болон эрсдэл бууруулах арга хэмжээ бүхий Галын аюулгүй байдлын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх<sup>4</sup></li> </ul>

<sup>2</sup> ОУСК-ийн БОЭМАА-ны удирдамж: Бохирдсон газар <http://www.ifc.org/wps/wcm/connect/4f4ca40048865833b49ef66a6515bb18/1-8%2BContaminated%2BLand.pdf?MOD=AJPERES>

<sup>3</sup> <http://ilo.org/global/standards/subjects-covered-by-international-labour-standards/lang-en/index.htm>

<sup>4</sup> ОУСК-ийн БОЭМАА-ны удирдамж: Нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа:

<http://www.ifc.org/wps/wcm/connect/dd673400488559ae83c4d36a6515bb18/3%2BCommunity%2BHealth%2BAnd%2BSafety.pdf?MOD=AJPERES>

Салбарын үйл ажиллагаа	Дэд үйл ажиллагаа	Дэд үйл ажиллагааны задаргаа	Байгаль орчны гол асуудал	Хяналт	Нийгмийн гол асуудал	Хяналт
	Үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламж	<ul style="list-style-type: none"> <li>Зөвшөөрөл авах үйл явц</li> <li>Геотехникийн судалгаа</li> <li>Газар шорооны ажил</li> <li>Бетон цутгах ажил</li> <li>Төмөр/каркас угсрах ажил</li> <li>Угсралтын ажлууд: сантехник, цахилгаан, дулааны холболт</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Барилгын талбайн бохирдол</li> <li>Тоосжилт, дуу чимээ, хийн хаягдлын ялгаруулалт, чичиргээний асуудлууд</li> <li>Экосистемын эвдрэл</li> <li>Амьдрах орчны хуваагдал</li> <li>Бэлчээрийн газрын алдагдал</li> <li>Бензин, ашигласан тос болон тосолгооны бусад материалаас үүсэх ус, хөрсний бохирдол</li> <li>Бохир ус зэрэг хог хаягдал үүсэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хүрээлэн буй орчинд аюултай бодис, хог хаягдал, тос тосолгооны материалыг хаяхгүй байж талбайг бохирдуулахаас зайлсхийнэ</li> <li>Тоосжилт, дуу чимээ, хийн хаягдлын ялгаруулалт, чичиргээ зэргээс урьдчилан сэргийлж, хамгаалах хяналтын арга хэмжээг хэрэгжүүлэх</li> <li>Экосистем, амьдрах орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах; экологийн чухал үйлчилгээний ач холбогдол, үйл ажиллагааг дэмжих зорилготой нөлөөлөх бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх</li> <li>Оролцоонд түшиглэсэн бэлчээрийн хяналт шинжилгээ бүхий газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх</li> <li>Бохирдолоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөө бүхий бохирдолын хяналтыг хэрэгжүүлэх (ус, хөрсний чанарын байнгын хяналт шинжилгээ)</li> <li>Аюултай, аюултай бус хог хаягдлыг бага хэмжээгээр гаргаж, хог хаягдлыг зохистой зайлуулж, байнгын хяналт шинжилгээ хийх зэргээр хог хаягдлын менежментийн хяналтыг хэрэгжүүлэх</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Олон нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал</li> <li>Хүний эрх – Хөдөлмөрийн нөхцөл, ажлын цаг, хөдөлмөрийн гэрээтэй холбоотой зөрчлүүд</li> <li>Нутгийн иргэдийн нүүлгэн суурьшуулалт</li> <li>Газрын маргаан – нүүлгэн суурьшуулалт, газар чөлөөлөлт</li> <li>Нутгийн иргэдийн эсэргүүцэл<sup>5</sup></li> <li>Соёлын өвийн алдагдал</li> <li>Байгууламжтай холбоотой эрсдэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулиудыг дагаж мөрдөх</li> <li>Нөлөөлөлд өртөх орон нутгийн иргэдэд үзүүлэх эрүүл ахуй, аюулгүй байдлын сөрөг нөлөөллөөс зайлсхийх</li> <li>Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, ОУХБ-ын Хөдөлмөрийн стандарт, Хамтын гэрээ болон олон улсын Хүний эрхийн конвенцийн заалтуудыг дагаж мөрдөх</li> <li>Газар ашиглах боломж хязгаарлагдсаны улмаас үүсэх нийгэм, эдийн засгийн сөрөг нөлөөллийг эд хөрөнгөө алдсан нөхөн төлбөр зэргийг ашиглан бууруулах, боломжтой бол зайлсхийх<sup>5</sup></li> <li>Холбогдолтой зөвшөөрлүүдийг зохих ёсоор авах</li> <li>Төслөөс нутгийн иргэдэд үзүүлж буй ийм төрлийн сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн төлөх<sup>6</sup></li> <li>Соёлын өвийг төслийн үйл ажиллагаанаас үүсэх сөрөг нөлөөллөөс хамгаалах; хамгаалан хадгалах; соёлын өвийг ашиглан олсон ашгийг шударга хувиарлалтыг дэмжих<sup>7</sup></li> <li>Байгууламжийн аюулгүй байдалтай холбоотой галын гол эрсдэл, хэрэглэгдэх норм, стандарт болон эрсдэл бууруулах арга хэмжээ бүхий Галын аюулгүй байдлын мастер төлөвлөгөөг хэрэгжүүлэх</li> </ul>
	Road	<ul style="list-style-type: none"> <li>Зөвшөөрөл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Биологийн олон</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Тоосжилт, дуу чимээ, хийн</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Олон нийт болон ажилчдын</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн</li> </ul>

<sup>5</sup> ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 5: Газар чөлөөлөлт: [http://www.ifc.org/wps/wcm/connect/3d82c70049a79073b82cfaa8c6a8312a/PS5\\_English\\_2012.pdf?MOD=AJPERES](http://www.ifc.org/wps/wcm/connect/3d82c70049a79073b82cfaa8c6a8312a/PS5_English_2012.pdf?MOD=AJPERES)

<sup>6</sup> ОУСК-ийн Гүйцэтгэлийн стандарт 7: Нутгийн уугуул иргэд: [http://www.ifc.org/wps/wcm/connect/1ee7038049a79139b845faa8c6a8312a/PS7\\_English\\_2012.pdf?MOD=AJPERES](http://www.ifc.org/wps/wcm/connect/1ee7038049a79139b845faa8c6a8312a/PS7_English_2012.pdf?MOD=AJPERES)

